

## 5

## ХҮН АМЫН БҮРТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

### Б. Саранчимэг

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод "Монгол Улсын хөгжил дэвшлийн үндэс нь оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эх оронч үзэлтэй, ёс суртахууны өндөр соёлтой, хөдөлмөрч, хууль ёсоо дээдэлдэг хүн гэж үзнэ" гэж тодорхойлсон.

"Хүн ам ба хөгжил" сэдвээр 1994 онд болсон Кайрын бага хурлаас засгийн газруудад зөвлөмж болгосон зорилго, чиглэлийг өөрийн орны эдийн засаг, нийгмийн болон хүн амын төлөв байдлын хандлагыг тусган хүн ам болон хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон улсын стандарт, аргачлалд нийцсэн хүн ам зүйн үнэн бодитой суурь мэдээллээр хангахын тулд ҮСГ анхааран ажиллаж байна.

Аль ч улс оронд байдаг хүн ам зүйн талаарх мэдээллийн эх үүсвэр болох хүн амын тооллого, иргэний бүртгэл, түүвэр судалгаа явуулах систем манай практикт ч хэрэгжиж байна. Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогыг дэлхийн олонх орны нийтлэг жишгээр 10 жилд нэг удаа явуулдаг уламжлалтай бөгөөд сүүлчийн тооллогыг 2000 онд явуулснаас хойш 3 жил өнгөрлөө. Тооллого хоорондын хүн амын тооны үнэн бодит байдал, чанар зарим талаар учир дутагдалтай байдаг нь сүүлчийн хоёр тооллогын хоорондох аймаг, нийслэлийн хүн амын мэдээллээс ажиглагдсан билээ.

Хэдийгээр, сүүлийн хүн амын тооллогын дүнгээр хийсэн судалгаагаар Монгол Улсын хүн амын албан ёсны статистик мэдээлэл хамралт сайтай, бодитой байна гэж үзэж байгаа боловч шилжилтийн үеийн эдийн засагтай бусад орнуудын нэгэн адилаар бидний өмнө тулгарч байгаа бэрхшээлүүдийн нэг нь хүн амын хөдөлгөөнийг бүрэн үнэн зөв бүртгэхэд анхаарах шаардлагатай байна.

Хүн амын статистик мэдээллийн эх үүсвэр болох хүн амын бүртгэлийн хөтлөлт, мэдээлэл цуглуулж байгаа байдал, хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ, хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтийг орон нутагт шалган зааварчлах ажлыг ҮСГ-аас 2002 оны эцсээр зохион байгуулсан юм. Энэ ажилд 21 аймгийн 63 сум, нийслэлийн 3 дүүргийн 6 хороо хамрагдсан юм.

Хүн ам, өрхийн бүртгэл нь иргэний бүртгэлийн үндсэн бүрэлдэхүүний нэг гэдгийг "Иргэний бүртгэлийн тухай" Монгол Улсын хуулийн 5.1-д заасан бөгөөд энэ нь хүн амын анхан шатны бүртгэл болж байгаа юм.

Үндэсний статистикийн газраас хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг 2001 онд шинэчлэн баталж, хөтлүүлж эхлээд байгаа бөгөөд цаашдаа хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн мэдээллээр "сан" бүрдүүлж, уг сангаас хүн амын тоо, бүтцийн холбогдох бүх мэдээллийг гаргаж байх ажлыг хэрэгжүүлснээр иргэдэд үзүүлэх төрийн нийгмийн үйлчилгээг зохих эздэд нь шуурхай хүргэх, орон нутгийн эдийн засаг, нийгмийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах мэдээллийн үндсэн эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлэх зорилготой юм.

### Хүн амын бүртгэлийн өнөөгийн байдал

1950 онд "Гэр бүлийн тухай" Монгол Улсын хууль гарч, 1951 оны 01 сарын 1-нээс иргэний гэр бүлийн байдлын 5 төрлийн хөдөлгөөн (төрөлт, нас барагт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт)-ийг бүртгэж эхэлсэн билээ.

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг баг, хороодын засаг дарга нар хөтөлж, жилийн эцсийн суурин хүн амын мэдээ, хүн амын ажил эрхлэлтийн судалгаа, нийгмийн зарим үзүүлэлт, тухайлбал тахир дутуу иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өнчин хүүхдийн тоо зэрэг баг, хороодын засаг дарга нар хүн амд төрийн үйлчилгээг хүргэхэд зайлшгүй шаардлагатай бүхий л мэдээллээ гаргадаг бөгөөд эдгээр мэдээллүүд нь сум, дүүрэгт нэгтгэгдээд аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэст, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс жил бүр ҮСГ-т ирүүлдэг. Төрөлт, нас барагт, гэрлэлт, хүүхэд үрчлэлт зэрэг иргэний гэр бүлийн байдлын талаарх бүртгэлийг сум, дүүргийн ЗДТГ-ын иргэний бүртгэлийн ажилтан бүртгээд, аймаг, нийслэлийн ЗДТГ-т, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас ИБМУТ-д сар бүр, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэст хагас, бүтэн жилээр ирүүлж, статистикийн хэлтэс ҮСГ-т, мөн сумын эмнэлгийн статистикч эмч төрөлт, нас барагт, өвчлөл зэрэг мэдээллүүдийг гаргаж, аймаг, нийслэлийн ЭМГ-т нэгтгэгдэн, ЭМЯ-д, ЭМЯ ҮСГ-т сар бүр ирүүлдэг тогтолцоотой.

Орон нутагт тухайлбал багийн түвшинд багийн Засаг дарга төрийн бүх төрлийн үйлчилгээг хүн амд хүргэх, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт хүн амын болон бусад нилээд олон төрлийн мэдээ, тайланг хариуцан ажилладаг. Мэдээ тайлан гаргах, нэгтгэх ажил багийн түвшинд механикаагүй учир хүндрэл их гардаг нь харагдаж байлаа. Түүнчлэн суманд 1-2 компьютер байдаг боловч зарим сумын Засаг даргын орлогч болон бусад мэдээ тайлан хариуцан гаргадаг ажилтнуудын компьютер ашиглах

чадвар, дадлаас шалтгаалан бараг ашиглагддаггүй, ашиглагдсан ч санхүүгийн тайлан нэгтгэх төдийхөнд л ашиглагддаг нь тодорхой харагдаж байлаа.

Сумдад иргэний гэр бүлийн бүртгэлийн асуудлыг янз бүрийн албан тушаалтнууд хариуцаж байдаг нь иргэний гэр бүлийн бүртгэл, мэдээллийн талаар мэдлэг дадлага олгоход хүндрэлтэй байдаг ажээ. Энэ асуудлыг сумдын Засаг даргын орлогч зохицуулж, аймгийн статистикийн хэлтэс хяналт тавин ажиллаж байгаа ч зарим талаар учир дутагдалтай тал ажиглагдаж байв. Нөгөө талаас сумын Засаг даргын орлогч ажлын ачааллаасаа шалтгаалаад мэдээ, тайлангуудыг салган, тамгын газрынхаа ажилтнуудад хуваарилан хариуцуулдаг бөгөөд орон нутагт ажиллаж байгаа ялангуяа төрийн байгууллагад ажилладаг мэргэжилтэй боловсон хүчинүүд ойр ойрхон солигддогоос ажил цалгардах, мэдээ тайлан хариуцах эзэнгүй болох, таслах, үнэн бодит байдал хангагдахгүй байдаг тал ч байна.

Хүн амын бүртгэлд гарч байгаа нэг хүндрэлтэй асуудал нь иргэний бүртгэл, эмнэлгийн дүн бүртгэлээр гарч буй төрсөн, нас барсан хүний тоо зөрүүтэй байдаг явдал юм. Энэ нь 2 байгууллагын бүртгэлийн хамрах хүрээ, мэдээлэх хугацаа, бүртгэх журмаас шалтгаалан (тухайлбал эмнэлгийн статистик төрсөн бүх эхчүүдийг харьялал харгалзахгүйгээр тухайн сумын ялангуяа аймгийн төвийн нэгдсэн эмнэлэгт тухайн сард төрсөн бүх хүүхдийг бүртгэдэг байхад иргэний бүртгэлийн ажилтан уул иргэний үндсэн харьяллаар нь бүртгэдэг) гардаг байна.

Орон нутагт хүн амын бүртгэлд гарч буй нэг томоохон асуудал нь албан ёсны бүртгэлгүйгээр өөр газарт шилжин суурьших явдал ихсэж, үндсэн захиргааныхаа хүн амын бүртгэлээс хасуулж, очсон газрынхаа захиргаанд бүртгүүлэхгүй байх явдал газар авсаар байна.

Энэ нь орон нутагт хүн амын бүртгэлийг зохих ёсоор хөтлөхөд ихээхэн хүндрэл учруулж байгаа болно. Сүүлийн жилүүдэд томоохон хот, суурин ялангуяа Улаанбаатар хотын хүн амын механик ёсөлт нэмэгдэж, хотжилт улам бүр нэмэгдэн, хөдөө орон нутгаас олон өрх айл төвийн бүс рүү тэр дундаа Төв аймгаар дамжин Улаанбаатар хот руу ирж суурьшиж байгаа энэ үед хөдөөгийн хөгжлийн асуудал нь анхаарал татсан нийгмийн томоохон асуудал болж байна. Түүнчлэн хөдөлмөрийн насны хүн амын тоо нэмэгдэж байгаа нь ажилгүйдлийг өсгөхийн зэрэгцээ ажлын байр хайн хот суурин газар руу шилжигчдийн тоог өсгөсөөр байна.

#### **Хүн ам, өрхийн бүртгэл хөтлөхийн ач холбогдол**

Орон нутагт хүн ам, өрхийн бүртгэлийг бүрэн хөтлөхийн ач холбогдол нь хүн амд төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний цар хүрээг тодорхойлох, түүний төрөл, хэлбэр тус бүрийг тухайн хүн амд хүргэх нэгдсэн бүртгэл, судалгаатай байж, бүх шатны засаг дарга нар орон нутагтаа эдийн засаг нийгмийн бодлого боловсруулах, иж бүрнээр нь хэрэгжүүлэхэд оршино. Үүний дотор:

- Төсөв, санхүү, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого боловсруулах

- Боловсролын үйлчилгээ үүний дотор сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын хүрэлцээ хангамж, боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх, зайны болон албан бус боловсрол олгох сургалтыг зохион байгуулах
- Ард түмний амьжиргааны түвшинг тогтоох, үүний дотор ядуурлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ талаар төр, засаг олон улсын байгууллагаас үзүүлж байгаа төрөл бүрийн дэмжлэг тусlamжийн үйлчилгээг холбогдох эзэнд нь хүргэх
- Ахмад настан, хүүхэд, эмэгтэйчүүд, тахир дутуу хүмүүс, хараа хяналтгүй бага насны хүүхдийн талаар баримтлах бодлого, чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээ, эмнэлэг, эмчлэн сэргийлэх байгууллагын боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх өргөжүүлэх, зах зээлийн системээр ажиллуулах, эмчилгээ үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэх
- Худалдаа, тээвэр, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйчүүдийн тоог бууруулах, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого чиглэл боловсруулах
- Орон сууцны бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх

#### **Хүн ам, өрхийн бүртгэлийг хөтөлж ирсэн нийтлэг зарчим**

Хүн ам, өрхийн бүртгэлийг хөтөлж ирсэн нийтлэг зарчим нь жилд нэг удаа шинэчлэн бүртгэдэг, ингэхдээ жил бүрийн мал тооллоготой хамтруулан явуулж ирсэн туршлага байдаг. Төв суурин газарт ч мөн энэ үеэр хүн ам, өрхийн бүртгэлийн шинэчилсэн бүртгэл явуулдаг нийтлэг жишиг болсон. Энэ нь зохион байгуулалт, хөрөнгө хүч хэмнэхэд ашигтай болох нь амьдралд батлагдсан гэж хэлж болох юм.

#### **Анхаарах асуудал**

Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг орон нутагт эргэн төлөгдөх нөхцлөөр санхүүжүүлж хэвлүүлэн, баг, хороонд тарааж хөтлүүлж байгаа юм. Гэвч зарим нэг аймаг энэ асуудлыг зохицуулж амжаагүйгээс хүндрэл гарч байгааг тэдгээр аймаг даруй шийдэх шаардлагатай.

Хүн ам, өрхийн бүртгэлийн жил бүрийн шинэчилсэн хөтлөлт бүх өрх, тэдгээрт оршин суугчдыг хамарч чадахгүй байгаа, ялангуяа төв суурин газарт шинээр шилжин ирсэн өрх, хүн ам, бүртгэлд хамрагдахгүй үлдэх явдал түгээмэл байгааг анхаарах

Нийтийн байр сууцанд оршин суугчдыг хамран бүртгэх талаар орон нутгийн ялангуяа төв суурин газрын төр захиргааны байгууллагаас зориуд анхаарах

## Цаашдын зорилт

1. Ард иргэд Монгол Улсын Үндсэн Хуулийн 6 зүйлийн 18-д заасан ... улсынхаа нутагт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох ..." гэсэн эрхээ эдлэхдээ бас байнга оршин суугаа газраасаа шилжин явахдаа бүртгэлээсээ хасуулж, ирсэн газартаа бүртгүүлж, "... хуулийг дээдлэн хүндэтгэх... " үүргээ зарим хүмүүс биелүүлэхгүй байгаагаас орон нутаг хүн амын тоогоо жил бүр бүрэн үнэн зөв тодорхойлж чадахгүй тохиолдол байгаа нь орон нутгийн захиргаа иргэдийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулах боломжгүй гэдгийг хүн амд зөв ойлгуулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах. Иргэд Үндсэн хуулиар заагдсан эрхээ эдэлж байгаа гэдгээр далимдуулан засаг захиргаандаа бүртгүүлэхгүй байгаа нь тэд төр, засгийн нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй болж байгаа гэдгийг иргэдэд ойлгуулах, тайлбарлах арга хэмжээ авах
  2. Улс орон даяар хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулж, хүн амынхаа тоо, хөдөлгөөнийг нэгдсэн болон аймаг, нийслэлийн мэдээллийн сан бүрдүүлж ашиглах. Энэ талаарх Улаанбаатар хотын захиргааны санаачлагыг дэмжиж, дэлгэрүүлэх
  3. Бүх бус нутгууд, ялангуяа Зүүн, Баруун бүсийн аймгууд хүн амаа Төвийн бус, Улаанбаатар хотод шилжин хүн амын төвлөрөл бий болох хандлагатай байгаа бөгөөд шилжих хөдөлгөөн нь хот, хөдөөгийн хөгжлийн ялгавартай байдал, ядуурлаас үүдсэн амьжиргааны эх үүсвэр хайсан алхам байдгийг ч бодолцож, хөдөө рүү чиглэсэн хөгжлийн зохистой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.
  4. Иргэний бүртгэлийн тухай" Монгол Улсын хуулийн 12.1 дугаар зүйлийн дагуу эцэг, эхчүүд хүүхдээ төрснөөс хойш төв суурин газарт 15 хоногт, сум багт 30 хоногийн дотор иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлэх ёстой. Мөн хуулийн 19.1 зүйлийн дагуу нас барсан хүнийг төв суурин газарт 5 хоногт, орон нутагт 10 хоногийн дотор иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлнэ гэж заасан заалтуудын хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг багийн Засаг даргаас эхлэн бүх шатанд авах, нөгөөтэйгүүр иргэдэд хууль сурталчлах, ухуулах таниулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.
  5. Иргэний бүртгэл, хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр хөтлөх болон хүн амын албан ёсны статистик мэдээллийн талаар "Статистикийн тухай", "Иргэний бүртгэлийн тухай", "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" Монгол Улсын хуулиудад заасан заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг бүх шатанд сайжруулах
  6. Хүн амын асуудлаар ямар нэгэн шийдвэр гаргахад ҮСГ-аас санал авдаг байх зарчим алдагдаж байгааг эргэж харах Тухайлбал; Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 120-р тогтоолын 3-т "...Хүн амын

жил бүрийн статистик мэдээний дагуу тухайн орон нутагт оршин сууж байгаа бэлэн хүн амын тоог үндэслэн нутгийн удирдлагын тухайн жилийн хувьсах зардлын хэмжээг тооцож байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаанд уурэг болгосугай ..." гэж заасныг "суурин хүн ам" гэж өөрчлөх

7. Ер нь ойрын жилүүдэд хүн амын бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг явуулж, иргэний бичиг баримтын зөрчлийг арилгах талаар ИБМУТ, УСГ, орон нутгийн засаг захиргаа хамтран ажиллах шаардлагатай байна.
  8. Албан ёсны шилжүүлэггүй айлын хүүхдүүд сургуульд орох боломж муу болсноос албан ёсоор гэрлэлтээ цуцлуулаагүй ч эхнэр нь хүүхдүүдийн хамт албан ёсны ХААТР маягтаа бичүүлэн өөр хот, сууринд шилжиж, нэхөр нь малтайгаа үлдэх, эсвэл нутаг орондоо ажлаа хийгээд үлдэх зэрэг нь хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрэйг өрх бүрт нээн хөтлөх, өөр газар руу шилжин явахдаа дэвтрээ авч, очсон газрынхаа баг, хороонд дэвтрээ өгч бүртгүүлэх ажилд хүндрэл учруулж байгааг анхаарч арга хэмжээ авах

## Дэвшүүлэх санал

### Төр засгийн зүгээс:

1. Сум, дүүрэг, аймаг, нийслэл улмаар улсын хэмжээний хүн амын улирал, жилийн эцсийн тоог (хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөнийг үндэслэн) үнэн бодитой тодорхойлохын тулд “Иргэний бүртгэлийн тухай” Монгол Улсын хуулийн зарим заалтад дараах өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай байгаа юм. Үүнд:

## Хуулийн 6 дугаар зүйлд:

- 6.4. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар иргэний бүртгэлийг **баг, хороогоор**<sup>1</sup> эрхлэн хөтөлж, холбогдох тайлан мэдээг гарган зохих журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл, мэдээллийн албан, иргэний бүртгэл мэдээллийн алба статистикийн **хэлтэс (тасаг)-т мэдээлнэ** гэж өөрчлөх Энэ нь иргэний бүртгэлийн мэдээлэл ялангуяа төрөлт, нас барагт, шилжих хөдөлгөөний мэдээллийн бодит байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Учир нь одоогийн тогтолцоогоор иргэний бүртгэл баг, хороогоор гардаггүй, жилийн эцэст багийн Засаг дарга нар өөрийн багийн иргэдийн иргэний гэр бүлийн байдлын мэдээллийг журналаас түүж авах гэж хоёр ажил болохгүй юм.

### Хуулийн 8 дугаар зүйлд:

- 8.3.2. "...бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв хөтлөх тайлан мэдээг нэгтгэж гаргах, **баг хороодод мэдээлэх** гэж нэмэлт оруулах саналтай байна. Энэ нь тухайн баг, хорооны төрөлт, нас барагт, шилжилт хөдөлгөөнийг үндэслэн баг, хорооны хүн амын тоог бодитой гаргах үндэс болно.

<sup>1</sup> Хуулийн холбогдох заалтанд шинээр оруулах саналаа тод хараар тэмдэглэв.

Хуулийн 9 дүгээр зүйлд

9.3. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн загвар, дэвтрийг хөтлөх журмыг Үндэсний статистикийн газар батална.

9.4. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг батлагдсан загварын дагуу сум, дүүргийн Засаг даргын тамгын газар хариуцан нөхөн төлөгдөх нөхцөлөөр хэвлүүлэн баг, хороодод тарааж, өрхийн дэвтэр хэвлүүлсэн зардлыг өрхүүдээс гаргуулж болно гэж нэмэх Улсын хэмжээнд нэг загварын, нэг ижил үзүүлэлтүүдтэй дэвтэр хөтлөх нь хүн амын мэдээллийн нэгдсэн баазтай болоход ач холбогдолтой бөгөөд өрхийн бүртгэлийн дэвтрийг хэвлүүлэх санхүүжилтийн асуудлыг хуульчилж өгч байгаа юм.

### Хуулийн 26 дугаар зүйлд

26.1. Иргэдийг аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг баг, хорооны тодорхойлолтыг үндэслэн сум, дүүргийн тамгын газар эрхэлж, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт мэдээлнэ гэж өөрчлөх. Энэ нь шилжигсдийн хамгийн ойрхон засаг, захиргааны нэгж нь баг, хороо бөгөөд тэндээс эхлэн хүн амын шилжих хөдөлгөөний мэдээ, тайланг эхлэн гаргаж байх нь шилжих хөдөлгөөний мэдээллийг үндэслэлтэй болгон сайжруулах ач холбогдолтой юм.

2. Иргэний болон хүн ам, өрхийн бүртгэлийг холбох эрх зүйн уялдааг тодорхой зааж өгөх
3. Сум, багийг хүн амын бүртгэлийн ажилтнаар бэхжүүлж, мэдээллийн технологийн техник хэрэгсэлтэй болгох, баг, хорооны зохион байгуулагчдын компьютер ашиглах болон хүн амын мэдээ, мэдээллийн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр орон нутаг өөрийн нөөц боломжоо ашиглан сургалтанд хамруулах
4. Бүх шатны Засаг дарга нар "Иргэний бүртгэлийн тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх, ялангуяа төрөлт, нас баралтыг хуулинд заасан хугацаанд бүртгүүлэх асуудлыг анхааралдаа авч, энэ талаар баг, хорооны Засаг дарга нарыг санаачлагатай, идэвхтэй ажиллуулах арга хэмжээ авах
5. Орон нутагт ажиллаж амьдарч байгаа хүмүүст орон сууцны нөхцөлөө сайжруулах, аж байдлаа дээшлүүлэхэд нь зориулж хөнгөлттэй зээл олгох, аймаг, сумын удирдлагууд хөдөө, орон нутагт ажиллаж байгаа мэргэжилтэй боловсон хүчинээ тогтворт, суурьшилтай ажиллуулах, залуучуудын чөлөөт цагаа идэвхтэй, үр бүтээлтэй өнгөрөөх, сум, орон нутгаа "эзгүйрүүлэхгүй" байхад өөрийн хөтөлбөр, бодлого, шийдвэрээ чиглүүлж, энэ талаар санаачлагатай ажиллах шаардлагатай байна.

6. Хүн амын шилжих хөдөлгөөний талаар төрөөс баримтлах бодлогыг оновчтой тодорхойлж, одоогийн үйлчилж буй хууль, дүрэм, журмыг эргэж харах шаардлагатай байна.

Үндэсний статистикийн газрын зүгээс:

1. Албан ёсны статистикийн мэдээлэгчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар байнга, шуурхай хангаж, үүний дотор сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарыг хүн амын мэдээ, мэдээллийн аргачлал, заалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр байнга хангаж, мэдээ, тайлангийн гаргалт, хамралт, үнэн бодит байдалд хийх хяналт, шалгалт, үнзлээс егех ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, шалгалтын мөрөөр арга хэмжээ авдаг байх
2. ИБМУТ болон хүн амын мэдээллээр хамтран ажилладаг яам, агентлагуудтай үр дүнтэй хамтран ажиллах, тэднийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах,
3. "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 16-р зүйлийн 3 дэх хэсгийн 1, 2, 4 –т заасан "...статистикийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хянаж, шалгах..., ...статистикийн мэдээллийн хамралт, үнэн зөв, шуурхай байдлыг шалгах, ... албан ёсны статистикийн мэдээлэл, судалгаанд шаардлагатай баримт бичиг үйлдэх, анхдагч бүртгэл хөтлөх, мэдээлэл сүдлэвээр үнэн зөв гаргаж мэдээлэх талаар зөвлөмж өгөх..." гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх ажлын цар хүрээг улам өргөжүүлэх
4. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг хөтлөх, компьютерт боловсруулах асуудлаар тусгайсан гарын авлага бэлтгэж, орон нутагт хүргүүлэх, энэ дэвтрийг хөтлөхийн ач холбогдолыг хүн амд (өрхийн гишүүдэд) ойлгуулах талаар аймаг, сум, багийн удирдлагуудтай хамтарч ажиллах
5. Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийг үндэслэн мэдээллийн сан бүрдүүлэхээр нийслэлийн хороодод одоо хэрэглэж байгаа программыг хөрвүүлэх, орон нутагт ашиглах боломжтой, энгийн хялбар болгож, аймгийн төвийн болон цахилгааны эх үүсвэртэй бусад сүмдэд хүргүүлэн, баг, хороодын энэ асуудал хариуцсан албан тушаалтнуудад сургалт явуулах асуудлыг аймаг, нийслэлтэй хамтран шийдвэрлэх шаардлагатай юм.
6. Иргэний төр бүлийн бүртгэлийн системийн өнөөгийн нөхцөлд хөдөөгийн багууд, нийслэлийн хороодыг хүн амын ердийн хөдөлгөөний мэдээллээр хэрхэн хангаж, хүн амын тоог тодорхойлж байх асуудлыг ИБМУТ-тэй хамтран шийдвэрлэх
7. Хүн амын сэсэгт, хөгжил өөрчлөгт, түүний эдийн засаг, нийтийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг ард иргэд ойлгуулах зэрэг асуудлаар улс, аймаг, сумын түвшинд тодорхой танилцуулга судалгаа хийж, нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг өргөжүүлэх
8. Хүн амын шилжих хөдөлгөөнийг статистикийн бүртгэл, мэдээлэлд бүрэн хамруулах арга замыг хайх, албан ёсны бүртгэлгүй шилжин явагчид, ирэгчдийг хэрхэн бүртгэлд хамруулах талаар ИБМУТ-тэй хамтран арга хэмжээ авах

Иргэдийн зүгээс цаашид анхаарах асуудлууд:

1. Иргэд иргэний үүргээ биелүүлж, хуулиа дээдлэн өөр газарт шилжин суурьшихаар явах, ирэхдээ засаг захиргаандаа журмын дагуу бүртгүүлэн, албан ёсны шилжүүлгээ хийлгэх, ингэснээр төрийн үйлчилгээг бүрэн хэмжээгээр хүртэхэд өөрсдөө идэвхтэй оролцох
2. Шинээр төрсөн болон нас барсан гэр булийн гишүүнээ хуулийн хугацаанд нь бүртгүүлэхэд иргэд санаачлагатай байх
3. Шилжин ирэгчдийг ажилд авч байгаа албан газар, аж ахуйн нэгж байгууллагын зүгээс тухайн иргэнийг харьялах засаг захиргааны байгууллагадаа дүрэм, журмын дагуу бүртгүүлсэн байхыг шаарддаг байх